

**МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2023 онысарын ...өдөр

Дугаар....

Улаанбаатар

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны "Дүрэм батлах тухай" А/245 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.4 дэх заалтыг "Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг Төрийн нарийн бичгийн даргын санал болгосноор Засгийн газрын гишүүн батална" гэж, 2.6 дахь заалтыг "Зөвлөлийн гишүүдийн тавиас доошгүй хувь нь төрийн бус байгууллагын төлөөлөл байна" гэж тус тус өөрчилөн найруулсугай.

2. Дүрмийн 2.9 дэх заалтад 11.7-д зааснаас бусад тохиолдолд Зөвлөлийн гишүүд нь зөвлөлөөр хэлэлцүүлэх төсөлд дүгнэлт гаргах шинжээчээр ажиллахгүй" гэсэн заалт нэмсүгэй.

3. Дүрмийн 11.7-д заасан "нэгжийн дарга" гэснийг "Зөвлөлийн дарга" гэж өөрчилсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/245 дугаар тушаалын 2.4, 2.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалд орсон өөрчлөлтийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлж, холбогдох захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтэс /Т.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

САЙД

Ж.ГАНБААТАР